МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
**АСУУЛГА**
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.07.16 № 01

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

"Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа"-ны талаар

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор улсын хөгжлийг боомилон, сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын дагуу авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн эсэх;

2.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын "Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа"-ны хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй тоо, мэдээлэл зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.АЛТАНГЭРЭЛ

2024000003